



"ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР" ХК
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2023 оны 04 сарын 26 өдөр

Дугаар 8/46

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан

хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйл, 61 дүгээр зүйлийн 61.1.7, 62 дугаар зүйлийн 62.1.1, 62.1.7, 65 дугаар зүйлийн 65.4, 67 дугаар зүйлийн 67.1, 71 дүгээр зүйлийн 71.1, 71.3 Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан "Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам"-ын 2.2, 2.3, "Газар Шим Үйлдвэр" ХК ("Компани" гэх)-ийн дүрмийн холбогдох заалтуудыг үндэслэл болгож, Компанийн Гүйцэтгэх захирлаас **ТУШААХ НЬ:**

1. Компанийн анхдагч зах зээлийн арилжаа амжилттай явагдаж, Компанийн хэлбэр өөрчлөгдөж буйтай холбогдуулан Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг ("Хурал") 2023 оны 06 дугаар сарын 14-ний өдөр, 10:00 цагт Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Энх тайвны өргөн төлөө 17, 14240, Блю ский цамхаг, Эмералд танхимд зохион байгуулж хуралдуулахаар шийдвэрлэсүгэй.
2. Хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлэхээр оруулсугай.
 - 2.1. Компанийн дүрмийн төслийг хэлэлцэн батлах;
 - 2.2. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох, батлах;
 - 2.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг батлах;
3. Хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2023 оны 05 дугаар сарын 20-ны өдөр байхаар тогтоосугай.
4. "Хурлын зар"-ыг энэхүү Тушаалын нэгдүгээр хавсралтаар баталж, хурал хуралдуулах тухай хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэх өдөр, журмыг дараах байдлаар тогтоосугай.
 - 4.1. Хурлын мэдэгдлийг 2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн дотор Санхүүгийн Зохицуулах Хороо болон Монголын Хөрөнгийн Биржид тус тус хүргүүлж олон нийтэд мэдээлсүгэй.
 - 4.2. Хурлын зарыг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл буюу өдөр тутмын сонин, орон даяар нэвтрүүлэг түгээдэг радио, телевизийн аль нэгээр дамжуулан 2023 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн дотор, мэдээллийн давталтыг 2023 оны 05 дүгээр сарын 26-ны өдрийн дотор анх мэдээлсэн хэлбэрээр мэдээлсүгэй.

- 4.3. Хурлын зар болон хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой материалыг 2023 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн дотор Үнэт цаасны компаниудад хүргүүлсүгэй.
5. Хуралд бэлтгэх явцад хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой “Хувьцаа эзэмшигчдийн танилцах боломжтой материалын жагсаалт”-ыг энэхүү Тушаалын хоёрдугаар хавсралтаар баталж, Хувьцаа эзэмшигч нар нь уг жагсаалтад дурдсан баримт, бичигтэй ажлын өдрүүдээр 9:00-17:00 цагийн хооронд Новел инвестмент ҮЦК - УБ хот, СБДүүрэг, 6-р хороо, Их тойруу 49, Өег тулга байр, 305 тоот хаяг, Газар шим үйлдвэр ХХК – УБ хот, БГДүүрэг, 20-р хороо, Үйлдвэрийн баруун бүс, 66/1, 66/2 тоот, Газар шим үйлдвэр ХХК-ийн үйлчлүүлдэг ҮЦК компаниудад ирж танилцаж болохыг мэдэгдсүгэй.
6. Хурлын даргаар Пүрэвсүх овогтой Нямдоржийг томилсугай.
7. Хурал зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:
- 7.1. Комиссын дарга:
Ц.Ганбат
- 7.2. Комиссын гишүүд:
- | | |
|---------------|---|
| П.Нямдорж | Новел инвестмент ҮЦК-н дэд захирал |
| Б.Энхбилэг | Газар шим үйлдвэр ХК-н Захиргаа хүний нөөцийн албаны дарга |
| Э.Ундрах | Газар шим үйлдвэр ХК-ийн Хүний нөөцийн менежер |
| Ч.Оюунчимэг | Газар шим үйлдвэр ХК-ийн Хангамжийн менежер |
| Н.Энхтүвшин | Газар шим үйлдвэр ХК-ийн Дотоод сүлжээний инженер |
| А.Солонго | Өмгөөллийн СноуХилл Консалтанси ХХН-ийн хуульч |
| А.Эрдэнэцэцэг | Газар шим үйлдвэр ХК-ийн Маркетинг борлуулалтын ахлах менежер |
8. Хурлын тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай:
- 8.1. Комиссын дарга:
С.Батчимэг
- 8.2. Комиссын гишүүд:
- | | |
|--------------|--|
| С.Батчимэг | Өмгөөллийн СноуХилл Консалтанси ХХН-ийн ахлах хуульч |
| Д.Хишигсүрэн | Газар шим үйлдвэр ХК-ийн Нягтлан бодогч |
| М.Даваажав | Өмгөөллийн СноуХилл Консалтанси ХХН-ийн хуульч |
| А.Тайван | Өмгөөллийн СноуХилл Консалтанси ХХН-ийн хуульч |
9. “Хурлын дэг”-ийг Тушаалын гуравдугаар хавсралтаар баталсугай.
10. “ТУЗ-ийн хараат бус гишүүнд тавигдах шаардлага”, “нэр дэвшигчийн бөглөх маягт”-ыг Тушаалын дөрөвдүгээр хавсралтаар баталж, нэр дэвшигчийн материал хүлээн авах сүүлчийн өдрийг 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрөөр тогтоосугай.
11. “ТУЗ-ийн бүрэн эрхийн хугацааны төсвийн санал”-ийг Тушаалын тавдугаар хавсралтаар баталсугай.
12. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа хүний нөөцийн албаны дарга албан тушаалтай Б.Энхбилэг, Хурал зохион байгуулах комисст үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ц.ГАНБАТ





**“ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР” ХК-ИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ЗАР**

“ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР” ХК (“Компани” гэх)-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал (“Хурал”)-ыг 2023 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн 10 цаг 00 минутад Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Энх тайвны өргөн төлөө 17, 14240, Блюскай цамхаг, Эмералд танхимд зохион байгуулж хуралдуулахаар шийдвэрлэсэн тул хувьцаа эзэмшигчид Та бүхнийг хуралдаа хүрэлцэн ирэхийг урьж байна.

Компанийн оноосон нэр: ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР ХК

Бүртгэлийн өдөр: 2023 оны 05-р сарын 20-ны өдөр хүртэл

Хурлаар хэлэлцэх асуудал:

Нэг. Компанийн дүрмийн төслийг хэлэлцэн батлах;

Хоёр. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох, батлах;

Гурав. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын төсвийг батлах;

Хувьцаа эзэмшигчдийн танилцах баримт бичгийн жагсаалт:

Нэг. Хурал зарласан шийдвэр болон хавсралт баримт, материалууд

Хоёр. ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийн танилцуулга;

Гурав. ТУЗ-ийн төсөв, цалин, урамшуулалтай холбоотой баримт, материал, санал

Дөрөв. Компанийн дүрмийн төсөл

Хувьцаа эзэмшигчид Компанийн байр буюу Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20-р хороо, Үйлдвэрийн бүс, 66/2 тоот хаягт ажлын өдрүүдэд 09.00 цагаас 18.00 цагийн хооронд ирж ээлжит бус хуралтай холбоотой баримт бичиг, тогтоолын төсөлтэй танилцах боломжтой бөгөөд нэмэлт мэдээлэл шаардлагатай бол **Хурал зохион байгуулах комиссын гишүүн Б.Энхбилэг** (утас: 880612868; e-mail-enkhbileg@gazarshim.mn)-тэй холбогдоно уу.

ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР ХК

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛААР ХЭЛЭЛЦҮҮЛЭХ
АСУУДЛЫН ХҮРЭЭНД КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ТАНИЛЦАХ БОЛОМЖТОЙ
БАРИМТ БИЧГҮҮДИЙН ЖАГСААЛТ**



№	Танилцах баримт бичгүүд	Бэлэн болгох хугацаа
1.	Хурал зарласан шийдвэр болон хавсралт баримт, материалууд	Бэлэн
2.	ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийн танилцуулга	2023.05.29-нөөс хойш
3.	ТУЗ-ийн цалин, урамшууллын төсөв, холбоотой баримт, материал, санал	Бэлэн
4.	Компанийн дүрмийн төсөл	Бэлэн
5.	2022 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан	Бэлэн



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ДЭГ

(Хурал 10:00 цагт эхэлж 14:00 цагт дуусах)

№	Дэд хэсэг	Хариуцах эзэн
1.	Хурлын ирцийг бүртгэх /ИТ компани/	ИТ компани, Тооллогын комисс
2.	Хурлын ирцийг мэдээлэх /тооллогын комисс/	
3.	Хурлын дарга Хурлыг нээж, хурлаар хэлэлцүүлэх асуудлууд болон хурлын дэгийг танилцуулах	Хурлын дарга П.Нямдорж
4.	Компанийн танилцуулга болон Компанийн нэмж гаргасан хувьцааг анхдагч зах зээлд нээлттэй худалдах ажиллагааны хэрэгжилт, үр дүн болон уг ажиллагаатай холбоотой гарсан зардлын тайланг танилцуулах	Гүйцэтгэх захирал Ц.Ганбат
5.	Санал өгөх процесс, технологийн талаар танилцуулга хийх, зааварчилгаа өгөх	ИТ компани, тооллогын комисс
6.	Хурлаар хэлэлцэх асуудлуудыг дарааллын дагуу танилцуулах, асуулт, хариулт, санал авах 1. Компанийн дүрмийн төслийг хэлэлцэн батлах; 2. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох, батлах; 3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын төсвийг батлах;	Хурлын дарга П.Нямдорж
7.	Тооллогын комиссын тогтоолыг танилцуулах	Тооллогын комисс
8.	Хурлаас гарах шийдвэр, тогтоолыг танилцуулах	Хурлын дарга П.Нямдорж, Гүйцэтгэх захирал Ц.Ганбат
9.	Хурлыг хаах	



**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХАРААТ БУС ГИШҮҮНД НЭР ДЭВШИХ ЭТГЭЭДИЙН МЭДҮҮЛЭГ**

Ерөнхий мэдээлэл		Хариулт		
1.	Овог: Нэр: Өөр нэртэй байсан эсэх: Хүйс (Эрэгтэй/Эмэгтэй):			
2.	Регистрийн дугаар:			
3.	Төрсөн огноо: Төрсөн газар (улс, аймаг, хот)			
4.	Оршин суугаа хаяг:			
5.	Иргэншил Хэрэв гадаад улсын иргэн байсан бол иргэншил авсан төрлийг бичнэ үү. (жишээ нь: төрөлт, иргэний харьяаллаа өөрчлөх, гэрлэлт)			
6.	Гэр бүлийн байдал			
	Овог, нэр	Регистрийн дугаар	Таны юу болох	Одоо эрхэлж буй ажил, албан тушаал
Компанийн тухай хуулийн шаардлага				
7.	өөрөө, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран Газар Шим Үйлдвэр ХК-ийн энгийн хувьцааны таваас дээш хувийг эзэмшдэггүй байх			
8.	өөрөө, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээд нь Газар Шим Үйлдвэр ХК-д ажил, албан тушаал эрхэлдэггүй, эсхүл сүүлийн 3 жилийн хугацаанд ажил, албан тушаал эрхэлж байгаагүй			
9.	төрийн үйлчилгээнийхээс бусад төрийн алба хашдаггүй байх			
10.	компанитай бизнесийн аливаа холбоогүй байх			
Мэдлэг боловсрол, ажлын туршлагатай байх				
11.	Баримт: Боловсролын гэрчилгээ, дипломын хуулбар -ыг хавсаргах			
	Боловсрол	Эзэмшсэн боловсрол/хамгаалсан цол	Суралцсан хугацаа	Сургуулийн нэр
				Улс хотын нэр
12.	Ажил эрхлэлт, туршлагын талаарх мэдээлэл;			
	Одоо ажиллаж байгаа байгууллага			
	Албан тушаалын нэр			
	Албан тушаал томилогдсон огноо			

Ажлын чиг үүрэг				
Ажлын хаяг, ажлын утасны дугаар				
10 жилийн хугацаанд ажиллаж байсан байгууллага	Албан тушаал/ эзэмшиж буй хувьцаа/ бизнесийн төрөл	Ажлын чиг үүрэг	Албан тушаалд томилогдсон огноо	Ажлаас гарсан шалтгаан

Гэмт хэрэгт холбогдож байгаагүй байх –

Баримт: Эрүүгийн хариуцлага, ял шийтгэл хүлээж байсан эсэх, хүлээж байгаа эсэх тодорхойлолт, лавлагаа-г хавсаргах

13.	Эрүүгийн хуульд заасан болон мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, авлига, хээл хахууль, эдийн засгийн гэмт хэрэг, зөрчилтэй холбоотойгоор эрүүгийн хариуцлага, шийтгэл хүлээгээгүй байх.	
14.	Эрүүгийн хуульд заасан болон мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, авлига, хээл хахууль, эдийн засгийн гэмт хэрэг, зөрчилтэй холбогдон шалгагдах болон шүүх хуралд шүүгдэгчээр, хэрэг бүртгэл, мөрдөн байцаалтын шатанд сэжиглэгдэж байгаа эсэх.	
15.	(а)гухайн хэргийг сүүлийн 10 жилийн дотор давтан үйлдсэн, насанд хүрээгүй буюу 18 нас хүрээгүй байхдаа үйлдсэн (б)тээврийн хэрэгслийн ашиглалт, өмчлөлтэй холбоотой хялбаршуулсан байдлаар шийдсэн хэргээс бусад төрлийн хэрэгт шүүхээс таныг буруутгаж байсан эсэх. Тийм бол хүлээлгэсэн хариуцлага, шийтгүүлсэн бол шийтгэл хүлээлгэсэн хугацаа, ногдуулсан хэрэг, торгуулийн талаар дэлгэрэнгүй бичнэ үү.	
16.	Санхүүгийн болон санхүүгийн бус үйлчилгээ, үйл ажиллагаатай холбоотой үүссэн гомдлын гол буруутан байсан эсэх.	
17.	Таныг санхүүгийн болон санхүүгийн бус байгууллага, виртуал хөрөнгө гаргагч, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэхтэй холбогдуулан мөрдөн шалгаж байсан уу? Тийм бол дэлгэрэнгүй бичнэ үү.	
18.	Таныг залилан, луйвар эсвэл ижил төстэй хэргийн шүүх хурал, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шинжээч, гэрчийн хувиар бус өөр этгээдийн хувиар нотлох баримт гаргаж өгөхийг шаардаж байсан уу? Тийм бол дэлгэрэнгүй бичнэ үү.	
19.	Таны ажиллаж байгаа эсвэл захирал, хувьцаа эзэмшигч, менежер, ажилтан, хянагчаар ажиллаж байсан байгууллага, түншлэлийг төрийн, мэргэжлийн эсвэл бусад зохицуулагч байгууллага шалгаж байсан уу? Тийм бол дэлгэрэнгүй бичнэ үү.	

20.	<p>Шүүхийн шийдвэрийн дагуу та төлбөл зохих төлөх ёстой өр төлбөрөө төлөхгүй байсан удаа байгаа юу? Тийм бол дэлгэрэнгүй бичнэ үү.</p> <p>Баримт: Шүүхийн шийдвэрээр гүйцэтгэх өр төлбөртэй эсэх талаар эрх бүхий байгууллагын тодорхойлолт-ыг хавсаргах</p>	
21.	<p>Таны ажиллаж байгаа эсвэл ажиллаж байсан байгууллага, түншлэлийг байгуулах, хянах, удирдахтай холбоотойгоор шүүхээс танд тэрхүү байгууллага, компани, гишүүний өмнөөс залилан, эрх мэдлээ хэтрүүлэн ашигласан хэрэг, бусад албан тушаалын гэмт хэрэгт иргэний эсвэл эрүүгийн хариуцлага хүлээлгэж байсан уу?</p> <p>Тийм бол дэлгэрэнгүй бичнэ үү.</p>	
22.	<p>Таныг захирал, хувьцаа эзэмшигч, менежер, ажилтан, хянагчаар ажиллаж байгаа болон ажиллахаа байснаас хойш нэг жилийн дотор тухайн байгууллага, түншлэлийг хүчээр татан буулгах эсвэл зээлдүүлэгчидтэйгээ тохиролцох, зөвшилцөх, зээлдүүлэгчид нь төлбөрөө буцаан аваагүй, бүгдийг нь хараахан буцаан аваагүй байхад үйл ажиллагааг зогсоож байсан тохиолдол гарч байсан уу?</p> <p>Тийм бол дэлгэрэнгүй бичнэ үү.</p>	
23.	<p>Таныг захирал, хувьцаа эзэмшигч, менежер, ажилтан, хянагчаар ажиллаж байсан бүртгэгдсэн, бүртгэгдээгүй байгууллага, түншлэлийн эрхийг цуцлах, хүчингүй болгож байсан уу?</p>	
<p>Ёс зүй нэр хүндтэй байх шалгуурын хүрээнд</p>		
24.	<p>Сүүлийн 1 жилийн хугацаанд салбарын ёс зүйн хэм хэмжээг зөрчөөгүй байх;</p>	
25.	<p>Сүүлийн 1 жилийн хугацаанд өөрийн буруутай үйлдлээс, салбарын ёс зүйн хэм хэмжээг зөрчсөнөөс үүдэн ажлаас халагдах арга хэмжээ авхуулаагүй байх.</p>	
26.	<p>Таны одоо бүртгэлтэй эсвэл бүртгэлтэй байсан байгууллагаас танд сахилгын болон аливаа төрлийн шийтгэл ногдуулж байсан эсэх ?</p> <p>Тийм бол дэлгэрэнгүй бичнэ үү.</p>	
27.	<p>Монгол Улс болон гадаад улсын нутаг дэвсгэрт хууль, журам, бизнесийн ёс зүй, дүрмийг зөрчсөн эсэх, бусдад энэхүү үйлдлийг хийхэд тусалсан хэрэгт холбогдоогүй байх;</p>	
28.	<p>Монгол Улсын болон гадаад улсын нутаг дэвсгэрт зохицуулалтын аливаа шаардлагыг хангахад, эсхүл мэргэжлийн болон ёс зүйн аливаа стандартыг дагаж мөрдөхөд бэлэн байх.</p>	
29.	<p>Та албан тушаалаасаа чөлөөлөгдөх, ажлаасаа халагдах эсвэл таныг мэргэжлээрээ ажиллахыг хориглож байсан уу?</p> <p>Тийм бол дэлгэрэнгүй бичнэ үү.</p>	

Ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх	
30.	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20, 21, 22 дугаар зүйлд харшлаагүй байх;
Бусад	
31.	Төрийн байгууллагын аливаа тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл хүссэн өргөдөлд татгалзсан хариу авч байсан эсэх ?
32.	Аливаа хугацаа хэтэрсэн зээлийн өргүй байх Баримт: Монгол банкны зээлийн мэдээллийн сангийн лавлагаа-г хавсаргах

Би энэ тодорхойлолтыг гаргаснаар мэдүүлсэн бүх мэдээллийг үнэн зөв, бүрэн гүйцэд гэдгийг баталж байна. Мөн дээр дурдсан хуулийн дагуу үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагын төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр ажиллах хугацаанд энэ асуулгад мэдүүлсэн мэдээлэлд өөрчлөлт орох тохиолдолд компанид нэн даруй мэдэгдэх болно.

Би дээрх мэдүүлгийн эсрэг баримт нотолгоо гарч ирсэн, эсхүл санаатай худал мэдүүлсэн тохиолдолд Зөрчлийн тухай хууль болон холбогдох бусад хуулийн дагуу хариуцлага хүлээх болно.

Овог, нэр:

Гарын үсэг:

Утас:

И-мэйл хаяг:

Сошиал хаяг:

Мэдүүлэг бөглөсөн огноо:

**ТУЗ-ИЙН БҮРЭН ЭРХИЙН ХУГАЦААНЫ
ТӨСВИЙН САНАЛ**



№	Төсөв	1 хүний (Т удаа)
1.	Цалин үндсэн (жилд 4 удаа) – ТУЗ-ийн дарга	1.300.000
2.	Цалин үндсэн (жилд 4 удаа) – ТУЗ-ийн гишүүн	1.000.000
3.	Хорооны даргын нэмэгдэл(улирлын) – 3 хороо	600.000
4.	Бичиг хэргийн зардал	200.000
5.	ТУЗ-ийн хурлын зардал (жилд 5 удаа)	500.000
6.	Уулзалт, тусгай арга хэмжээ, бусад	600.000

“ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ШИМ
ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ



2023 оны 06-р сарын 14-ны өдөр

№

Улаанбаатар хот

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Ердийн болон
Хараат бус гишүүдийг сонгох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь хэсэг, 77 дугаар зүйлийн 77.4 дэх хэсэг, 2023 оны 06 дугаар сарын 14-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаас **ТОГТООХ НЬ:**

Нэг. ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР ХК-ийн (цаашид “компани” гэх) Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүнээр дараах этгээдүүдийг сонгосугай.

1.1. Ердийн гишүүдээр:

- 1.1.1. Монгол Улсын иргэн
- 1.1.2. Монгол Улсын иргэн
- 1.1.3. Монгол Улсын иргэн
- 1.1.4. Монгол Улсын иргэн
- 1.1.5. Монгол Улсын иргэн
- 1.1.6. Монгол Улсын иргэн

1.2. Хараат бус гишүүдээр:

- 1.2.1. Монгол Улсын иргэн
- 1.2.2. Монгол Улсын иргэн
- 1.2.3. Монгол Улсын иргэн

Хоёр. Хууль тогтоомж, компанийн засаглалын кодекс, Компанийн дүрэм болон ТУЗ-ийн үйл ажиллагаатай холбоотой дүрэм, журмуудыг мөрдөж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нийт гишүүдэд үүрэг болгосугай.

Гурав. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын шийдвэрийг хэрэгжүүлж хуульд заасан хугацаанд зохих журмын дагуу холбогдох бүртгэлийн байгууллагад хүргүүлж, бүртгүүлэхийг Гүйцэтгэх захирал \Ц.Ганбат\, Өмгөөллийн “Сноу Хилл Консалтанси” ХХН-ийн хуульч А.Солонго, А.Тайван нарт, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг албан тушаалтай \Ц.Төгсөө\ нарт тус тус үүрэг болгосугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН

ХУРЛЫН ДАРГА

.....

П.НЯМДОРЖ

ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 06-р сарын 14-ны өдөр

№

Улаанбаатар хот

**Төлөөлөн Удирдах Зөвлөлийн бүрэн эрхийн
хугацааны төсвийн саналыг батлах тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13, 62.1.15 дахь хэсэг, 2023 оны 06 дугаар сарын 14-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаас **ТОГТООХ НЬ:**

Нэг. ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР ХК-ийн (цаашид “компани” гэх) Төлөөлөн Удирдах Зөвлөлийн бүрэн эрхийн хугацааны төсвийн саналыг Энэхүү тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсугай.

Хоёр. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн цалин, урамшууллын зардалд хяналт тавьж ажиллахыг ТУЗ-ийн дарга \.....\ -д үүрэг болгосугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН

ХУРЛЫН ДАРГА

.....

П.НЯМДОРЖ

**“ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ**

2023 оны 06-р сарын 14-ны өдөр

№

Улаанбаатар хот

**Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Ердийн болон
Хараат бус гишүүдийг сонгох тухай**

Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх хэсэг, 2023 оны 06 дугаар сарын 14-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаас **ТОГТООХ НЬ:**

Нэг. ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР ХК-ийн (цаашид “компани” гэх) дүрмийг энэхүү тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсугай.

Хоёр. Компанийн дүрмийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга \.....\ болон Гүйцэтгэх захирал \Ц.Ганбат\ нарт үүрэг болгосугай.

Гурав. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын шийдвэрийг хэрэгжүүлж хуульд заасан хугацаанд зохих журмын дагуу холбогдох бүртгэлийн байгууллагад хүргүүлж, бүртгүүлэхийг Гүйцэтгэх захирал \Ц.Ганбат\, Өмгөөллийн “Сноу Хилл Консалтанси” ХХН-ийн хуульч А.Солонго, А.Тайван нарт, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг албан тушаалтай \Ц.Төгсөө\ нарт тус тус үүрэг болгосугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН

ХУРЛЫН ДАРГА

.....

П.НЯМДОРЖ